



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 0/257

Улаанбаатар хот

Инженерийн баг, хяналтын инженер
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ИНД-171.79 Үйл ажиллагааны зааврын 6.3 дахь “Туршилт шалгалтаар байгууламжийг түр ажиллуулах журам” -ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Улаанбаатар хотын нислэгийн хөдөлгөөний удирлагын төвд суурилагдсан /The Automated Message Handling System/ Автоматаар мессеж боловсруулах системийг Хятад улсын Бээжин хотын нислэгийн хөдөлгөөний төвтэй /Aeronautical Telecommunication Network/ нисэхийн цахилгаан холбооны сүлжээний замчлалын төхөөрөмж ашиглан холбож турших ажлыг 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэсүгэй.

2. Туршилт шалгалтын ажил хийж гүйцэтгэх хяналтын инженер, инженерийн багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Багийн ахлагч:	П.Нарантуяа	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Мэдээлэл технологийн тасгийн ахлах инженер
Гишүүд:	Т.Сутай	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Мэдээлэл технологийн тасгийн инженер
	С.Угтахбаяр	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Мэдээлэл технологийн тасгийн инженер
	Г.Нандин-Эрдэнэ	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Мэдээлэл технологийн тасгийн инженер
	С.Билгүүн	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Мэдээлэл технологийн тасгийн инженер

Хяналтын


инженер: Б.Цэнд-Аюуш

Техник хангалт, навигацийн үйлчилгээний
албаны Холбооны хэсгийн Мэдээлэл
технологийн тасгийн ахлагч инженер

3. Тоног төхөөрөмжүүдийг турших ажлыг агаарын навигацийн үйлчилгээний байгууламжуудын хэвийн ажиллагаанд сэргээр нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөн ажиллаж, зохих журмын дагуу удирдлагад тайлагнахыг инженерийн багийн ахлагчид үүрэг болгосугай.

4. Туршилтын ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба /Д.Баяртогтох/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН